

Цаг уур, орчны шинжилгээний газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны 2024 оны нэгдүгээр улирлын ажлын товч танилцуулга

2024.04.30

Цаг уур, орчны шинжилгээний газрын дэргэдэх ёс зүйн дэд хороо нь Газрын даргын 2024 оны 01 сарын 12-ны өдрийн А/08 тоот тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Тайлант хугацаанд Ёс зүйн дэд хорооны хуралдааныг 4 удаа зохион байгуулан, 5 гомдол, мэдээллийг хүлээн авч хуулийн хугацаанд хариу өгч ажилласан. Хуралдааныг төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хүрээнд ёс зүйн дэд хорооны ажиллах журмын дагуу зохион байгуулсан.

Нэгдүгээр хуралдаанаар: Цаг уур, орчны шинжилгээний газрын Ёс зүйн дэд хорооны 1 дугаар хуралдааныг 2024.01.22-ны өдөр дарга Н.Энхмаа удирдаж, нарийн бичгийн дарга М.Батжаргал, гишүүдэд Д.Батдорж, М.Лхагвасүрэн, О.Оюунчимэг, Ж.Энхчимэг, Э.Энхзаяа нар оролцож, гишүүдийн ирц 100%-тай, төв байрны 2 давхар 201 тоотод 14 цагт эхлэв. Уг хуралдаанаар Ёс зүйн дэд хорооны нэгдүгээр улиралд хийж гүйцэтгэх ажлыг төлөвлөгөөг гишүүдийн саналыг авч баталсан ба ёс зүйн дэд хорооны удирдлага, зохион байгуулалт, төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим, нийтлэг хэм хэмжээг сахиулах ажлын хүрээнд 7 ажил, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг хянан шийдвэрлэх ажлын хүрээнд 6 ажлыг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллалаа. Үүнээс төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг байгууллагын бүх ажилчидад танилцуулах ажил хийгдээгүй ба уг хөтөлбөр УИХ-аас батлагдсан боловч төрийн мэдээлэл сэтгүүлд хэвлэгдээгүй хүлээгдэж байгаатай холбоотой болно. Уг хуралдаанаар 2 гомдлыг дэд хорооны гишүүдэд хувиарласан байна.

Хоёрдугаар хуралдаанаар: Цаг уур, орчны шинжилгээний газрын ёс зүйн дэд хорооны 2 дугаар хуралдааныг 2024.03.05-ны өдөр дэд хорооны дарга Н.Энхмаа удирдаж, нарийн бичгийн дарга М.Батжаргал, гишүүдэд Д.Батдорж, М.Лхагвасүрэн, О.Оюунчимэг Ж.Энхчимэг Э.Энхзаяа нар оролцож, гишүүдийн 100%-ирцтэй, төв байрны 2 давхар 201 тоотод 15 цагт эхлэв. Хуралдаанаар хяналт шалгалт хийсэн дэлгэрэнгүй танилцуулгыг сонсож, хэлэлцэж төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан эсэхэд дүгнэлт гаргаж ажилласан байна.

Гуравдугаар хуралдаанаар: Цаг уур, орчны шинжилгээний газрын ёс зүйн дэд хорооны 3 дугаар хуралдааныг 2024.03.19-нй өдөр дэд хорооны дарга Н.Энхмаа удирдаж, нарийн бичгийн дарга М.Батжаргал, гишүүдэд Д.Батдорж, М.Лхагвасүрэн, О.Оюунчимэг Ж.Энхчимэг, Э.Энхзаяа нар оролцож гишүүдийн ирц 100%-тай, төв

байрны 2 давхар 201тоотод 14 цагт эхлэсэн бөгөөд хяналт шалгалт хийсэн ёс зүйн дэд хорооны гишүүдийн танилцуулгыг сонсож, хэлэлцэж, ёс зүйн дэд хорооны дүгнэлт шийдвэрийг гаргасан байна. БОАЖЯамны ёс зүйн дэд хорооноос ирсэн дарга, гишүүд дэд хорооны үйл ажиллагаатай танилцаж, хоёрдугаар хуралдаанаар шийдвэрлэсэн “ёс зүйн зөрчил гаргасан эсэх дүгнэлт”-тэй танилцаж, зөвөлгөө өгч ажилласан.

Дөрөвдүгээр хуралдаанаар: Цаг уур, орчны шинжилгээний газрын ёс зүйн дэд хорооны 4 дугаар хуралдааныг дэд хорооны дарга Н.Энхмаа удирдаж, нарийн бичгийн дарга М.Батжаргал, гишүүдэд Д.Батдорж, О.Оюунчимэг Ж.Энхчимэг Э.Энхзаяа нар оролцож, М.Лхагвасүрэн чөлөөтэй, гишүүдийн ирц 85%-тай, төв байрны 1 давхар 101тоотод 11 цагт эхлэсэн ба ёс зүйн дэд хорооны гишүүдэд төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөр батлагдсантай холбогдуулан мэдээлэл өгч Монгол улсын ёс зүйн хорооны 05 дугаар тогтоолтой танилцаж мэдээлэл солилцсон байна.

Ёс зүйн дэд хорооны гишүүдийн нийгмийн баталгааны асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргагчид нэгдүгээр улиралын урамшууллын асуудлыг оруулах, дэд хорооны гишүүдийг ажлын ирц, идэвх оролцоог хэрхэн дүгнэж байхыг шийдвэрлэсэн байна.

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА

Н.ЭНХМАА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

М.БАТЖАРГАЛ

2024.04.30